

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Хурлын огноо: 2021 оны 4 сарын 30-ны өдөр;

Хурлын байршил: live.ard.mn сайтаар дамжуулан;

Хурал эхэлсэн цаг: 11:00 цаг;

Хурлын дарга: Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Цаашид “ТУЗ”гэх)-ийн дарга Ч.Ганхуяг;

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашгийн тайлан танилцуулах;
3. 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нөхөн сонгох;
5. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах;

Хурлын ирц: 241,673,943 ширхэг хувьцаа буюу хувьцаа эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдийн 87.54 %-ийн ирцтэй

Хурлын дарга Ч.Ганхуяг: Манай Ард Кредит ББСБ ХК-ийн 2020 оны тайлангийн ХЭХ маань эхлэхэд бэлэн болоод байна. Юуны түрүүнд хуралдаа идэвхийлэн оролцож буй нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлье. Бид та бүхэндээ үзүүлж харуулах, ярих, зөвлөх маш их олон үйл явдлаар дүүрэн сайхан он жил болж өндөрлөлөө. Бид өнөөдрийн танилцуулгаа бэлтгэхдээ зөвхөн Ард Кредит ББСБ ХК-ийн 2020 оны гүйцэтгэлийг танилцуулаад зогсохгүй Ард Кредит ХК-ийн хувьд мөн зарим талаараа Ард Санхүүгийн Нэгдэл түүний бусад холбоотой компаниудын эхний улиралд 2021 оны эхний улиралд ямар үйл явдал өрнөв өө, ямар амжилт, бэрхшээл сорилт учрав аа гэдэг талаар өнөөдөр ярилцана гэж тооцож байгаа. Мөн манай Хувьцаа эзэмшигч болчихоод бүртгэлийн өдрөөс хойшхи хувьцаа эзэмшигч болсон хүмүүс энэхүү хурлаар фэйсбүүк лайваар оролцож байна гэж ойлгож байгаа та бүхэндээ бас талархал илэрхийлье. Мөн Ард Кредит Ард СН –ийн баг хамт олонд, энэ ам бүлд тавтай морилно уу гэж уримаар байна.

Нээлттэй компаниуд ХЭХ-ыг хийгээд дуусгах сүүлчийн өдөр нь өнөөдөр байгаа бид сүүлийн тэмээний ачаа хүнд гэдэг шиг өнөөдөр 11.00 цагаас Ард Кредит ХК-ийн ХЭ хурлийг хийнэ, 14 цагаас АСН-ийн ХЭ хурлыг хийнэ, 17 цагаас Е-Мони гээд бас нэгэн шинэ манай компанийн бүрэлдэхүүнд багтан орсон компани байгаа түүний ХЭХ-ыг хийнэ, тэгээд 19 цагаас мөн фэйсбүүк бусад сошиал медиагаар та бүхэндээ энэ хурлуудаар зарлаж амжаагүй байгаа чухал гоё мэдээнүүдийг хуваалцах болноо. МХБ арилжаа эхлээд цаг гаруй хугацаа өнгөрч өнөөдрөөр тасалбар болгоод АСН, Ард Кредит ХК-ийн хувьцаа эзэмшигчидэд хувь тэнцүүлсэн АрдКойн өгнө гэдгийг санаад манайхан арилжаандаа оролцоорой гэж хүсье. За ингээд манай Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК компаниас Г.Алтансүх оролцож байгаа, Г.Алтансүх маань өнөөдрийн энэ хуралд зохион байгуулагчаар мөн Тооллогын комиссын ажлыг хариуцаад хийж байгаа. Бид Ковидтой, хөл хориотой энэ хүнд хэцүү үед үйл ажиллагаа явуулж байна. Монголчууд бид бол гэхдээ ямар ч тохиолдолд ажрахгүйгээр ажил амьдралаа залгуулаад явуулчихдаг хүмүүс. Энэн дундаа манай Ард Санхүүгийн Нэгдлийн хүмүүс, хувьцаа эзэмшигчид 2 дахь жилдээ хурлаа цахимаар технологийн шинэ дэвшилийг ашиглаад хурлаа явуулаад, хуулийнхаа шаардлага үг үсгэнд, үйл явцаа ил тод байх

зарчманд ингээд явуулж байна. Алтансүх маань өнөөдрийн хурлынхаа ирцийг танилцуулсанаар, бид хэд хурлынхаа дэг, хэлэлцэх асуудлаа батлаад тэгээд танилцуулгууд руугаа орох юм байгаа юм. Манай хурал явагдахад хангалттай ирц бүрдсэн байна уу Алтансүх ээ?

Хурлын зохион байгуулагч Г.Алтансүх: Энэ өдрийн мэнд хүргэе хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчиддаа. Ирц бол одоогийн байдлаар 80.6 хувьтай явж байна, ирцийг бидний төлөвлөснөөр 11.15 минутанд хаахаар төлөвлөсөн байгаа тэгэхээр одоо ирцийг зарлахад 4 минут дутуу байнаа гэсэн үг.

Хурлын дарга Ч.Ганхуяг: За 80 гаруй хувьтай ирц явж байгаа юм байна. ХЭ бүртгэлийн өдөр хэднээр байлаа?

4/09-ний өдрөөр Ард Кредит ХК-ийн хувьцаа эзэмшигч байсан хүмүүс санал өгөх эрхтэйгээр live.ard.mn-ээр ороод очсон кодоор хуралдаа оролцож байгаа юм шүү. 4/09-өөр бүртгэлдээ хамрагдсан хэрэглэгчид бидний өмнө нь зарлаад байсан ноогдол ашгийг авах эрхтэй байгаа юм. 4/09-өөс арилжаанд ороод, хувьцаа аваад манай хувьцаа эзэмшигч болсон хүмүүс бас гар хоосонгүй ээ. Өнөөдөр бид хуралд оролцож байгаа нөхдүүдээ бид койноор урамшуулж байгаа, 100 койн өгч байгаа. За мөн 50 ширхэг хувьцаа тутамд нь өнөөдрийн өчигдрийн арилжаагаар хаагаад жагсаалтыг нь гаргаж байгаад мөн койны урамшууллыг та бүхэндээ өгч байгаа. Тэгэхээр та 50 ширхэг хувьцаатай бол 1 ширхэг АрдКойн авна, 500-тай бол 10 АрдКойн, 5000-тай бол 100 койн авнаа. Койнтой холбоотой гоё мэдээг өнөөдөр бид нар 7 цагаас зарлах болно. Тэрийг та нар мэдэж байгаа. Энэ цагийг ашиглаад би хуралдаа оролцож байгаа нийт нөхдүүдээ танилцуулаад авах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Хуралд оролцож байгаа ТУЗ-ийн гишүүд өнөөдөр энд байж байна. ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүд өөрсдийгөө танилцуулна уу.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг: Сайн байцгаана уу? Намайг Чулууны Ганзориг гэдэг 2013 оноос хойш Ард Кредит ХК-ийн ердийн гишүүнээр ажиллаж байгаа, одоогийн байдлаар Ард Экс буюу DAX-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа хүн байнаа.

ТУЗ-ийн гишүүн Б.Ганбат: Сайн байцгаана уу, намайг Барамсайн Ганбат гэдэг. Хараат бус гишүүн, дотоод аудитын хорооны дарга. 2013 оноос хойш Аудитын хорооны гишүүнээр ажиллаж байгаа. Энэ хуралд оролцож байгаад талархалаа илэрхийлье мөн амжилт хүсье.

ТУЗ-ийн гишүүн В.Ганзориг: Сайн байцгаана уу, би Ванчигийн Ганзориг. Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажилдаг.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Манай Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн өөрийгөө танилцуулах уу?

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Сайн байцгаана уу, та бүхэнд ХЭХ-ын өдрийн мэнд хүргэе. ТУЗ-ийн дарга, гишүүд мөн хуралдаа оролцож буй нийт хувьцаа эзэмшигчиддээ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хуралд амжилт хүсье.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Манай С.Бямбадэлгэр өнөөдөр бидэнд хэлмэрч хийж байна. С.Бямбадэлгэртээ амжилт хүсье. Дэгийн дагуу бид хэсэг хэсэг завсарлагааны паус аваад явчиж байх хэрэгтэй юм байна лээ. С.Бямбадэлгэрийн гарыг бас хааяа чөлөөлж өгч байхгүй бол хэдий дуу чимээ гаргахгүй ярьж байгаа ч гэсэн ам хоолой нь хатдаг болов уу гэж төсөөлж байна. Бүр болохгүй бол С. Бямбадэлгэртээ надад хэлээрэй.

Хурлын зохион байгуулагч Г.Алтансүх: Ард Кредит ББСБ ХК-ийн ХЭХ-ын Тооллогын комиссын тогтоол № 1, 2021 оны 4 сарын 30. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн тогтоох нь:

- Саналын эрх бүхий энгийн хувьцааны 141,673,943 ширхэг буюу 86.31 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн тус хурал хүчин төгөлдөр болсоныг мэдэгдэж байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Хурал албан ёсоор хүчин төгөлдөр байдалтайгаар нээгдсэнийг мэдэгдэе. Ингээд Тооллогын комиссын тогтоол гарсан байна. Өнөөдрийн хуралд оролцож байгаа удирдлагын багын нөхдүүд, зохион байгуулагчид, Блүмсбюри компанийн, Хуулийн компанийн, Аудитын компанийн нөхдүүдэд талархал илэрхийлье. Мөн өнөөдөр энд ажиглагчаар оролцож байгаа ТУЗ-д нэрээ дэвшүүлээд ТУЗ-д сонгогдохоор байж байгаа ажиглагчид байж байгааг та бүхэн анзаарсан байх, эдгээр хүмүүсийг хэлэлцэх асуудлынхаа дагуу та биднийг дараачийн ХЭХ хурал хүртэл төлөөлөх аваад явах хүмүүсийг зохих журмынх нь дагуу танилцуулах болно.

Хурлынхаа дэг, хэлэлцэх асуудлууд:

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн:

Хурлын дэг

11:20 Хэлэлцэх асуудлыг жагсаалтын дагуу танилцуулга хийх

12:20 Асуулт, Хариулт

12:35 Санал хураалт

12:50 Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах

13:00 Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурлыг хаах

Хэлэлцэх асуудал

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлт
2. 2020 оны ногдол ашгийн тайлан
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, ТУЗ-ийн товч тайлан
4. Төлөөлөн Удирдах гишүүдийг нөхөн сонгох
5. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг танилцуулах

Та бүхэнд материалуудыг хүргүүлсэн учраас нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 3 сарын 31-ний байдлаар 10,071 байсан 4,700-аад хүн бүртгүүлсэн байдалтай байна гэсэн мэдээлэл авсан байгаа.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Энэ дээр би нэг санал байна. Хэлэлцэж байгаа асуудлуудаа дэлгэцэн дээр томоор гаргаад явбал илүү таатай байх.

Асуулт хариултын хэсэг гаргасан байгаа, санал хураалтууд явагдана. Зохион байгуулагчдын зүгээс надад ХЭХ-д санал эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчийн тоог мэдээлээрэй. Хэдэн хүн live.ard.mn-ээр ороод хуралдаа оролцож байна вэ гэдгийг. Энэ бол байгууллагын ой санамжинд үлдээд явах асуудал байгаа, нөгөө талдаа манай фейсбүүк дээр ирүүлээд байгаа асуултуудыг бас наашаа базаж явуулаарай. Асуултуудад нь хариулаад явна. Хувьцаа эзэмшигчид комментэн дээрээ #ABD гээд явуулаарай. Багийн нөхдүүд өгсөн кодоор орж чадахгүй байна, код зөрсөн байна, email ирсэнгүй гэсэн хүмүүс рүү хувийн чатаар холбогдоод асуудлуудыг нь шийдээд хуралдаа оролцох боломжийг гаргаад өгөөрэй гэж хүсье.

Бидний хувьд цахим хурал явуулах нэг зүйл байгаа Г.Алтансүх хөндлөнгийн хараат бус байдлаар ирцийг та бүхэнд танилцуулсан шиг хурлаас гарах шийдвэрүүдийг мөн цахимаар тоолоод та бүхэнд мэдээлээд явна.

Хурлын дэг, хэлэлцэх асуудлуудын тухайд ТУЗ нь 1 сарын өмнө хуралдаад саналаа гаргаад та бүхнээс саналуудыг аваад батлаад энэ хурлыг явуулж байгаа юм шүү. Тэгэхээр ТУЗ-ийн зүгээс батласан дэгийн дагуу, баталсан хэлэлцэх асуудлуудынхаа дагуу, Компанийн хуулийн дагуу өнөөдрийн хурал явагдах болно.

Манай Хувьцаа эзэмшигчид энэ 12:30 –аас хурал дуусахаас өмнө санал хураалтанд оролцож ТУЗ-ийн гишүүдээ сонгох, дүрмэнд өөрчлөлт оруулах, ТУЗ-өөс гаргасан дүгнэлт, санхүүгийн тайлангаа батлаад явна. Өөр зүйл байхгүй бол ингээд хэлэлцэх асуудлууд руугаа оръё.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан

Компанийн хувьд Гүйцэтгэх захирлаар Г.Тэлмэн ажиллаж байгаа. 2020 оны 2 сараас эхлэн Монгол Шуудан ХК-ийн Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байгаад орж ирж ажилсан байгаа. ТУЗ-ийн гол ажил нь компанийн тасралтгүй үйл ажиллагааг хангахын тулд Гүйцэтгэх удирдлагыг томилох, түүний ажилд хяналт тавих мөн шаардлагатай бол хариуцлага тооцох, шагнаж урамшуулах үндсэн үүрэгтэй ажилдаг байгаа. ТУЗ-ийн зүгээс өнөөдөр албан тайлангуудыг тавьна, түүний цаана бид Гүйцэтгэх удирдлага болигдсон 2019 оны 6 сараас эхлээд 2020 оны 1 дүгээр сар хүртэл үүрэг гүйцэтгэгчтэй ажилсан байгаа. Манай энэ компанийн Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг маань өөр ажил рүү шилжихтэй холбоотой завсар үүссэн бидний хувьд энэ компанийн үйл ажиллагааг тасалдаггүй явуулах тал дээр сайн ажилласан гэж дүгнэж байгаа. 2020 онд Ковид, хөл хорио гээд хүнд хэцүү үетэй зэрэгцээд хамт Г.Тэлмэн маань орж ирээд өөрөө банк, санхүүгийн байгууллагын туршлага хуримтлуулах, мэдэхгүй чадахгүй зүйлд нь бид хажуунаас нь дэмжих байдлаар ажиллаад гайхамшигтай сайхан үр дүнг гаргаж чадсан. Бид баг байж чадсан. Хүчтэй, хамтдаа байж чадсан гэдгийг цохож хэлье. Ингээд Г.Тэлмэн-д микрофоныг шилжүүлъя.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Баярлалаа ТУЗ-ийн даргадаа, ингээд нийт Хувьцаа эзэмшигчдэдээ 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулъя.

Нэгэнт 2021 оны I улирал болоод өнгөрсөн байгаа тул 2021 оны 3 сарын 31-ний байдлаар I улирлын дүнтэй 2019 болон 2020 дүнтэй харьцуулж харуулж байна.

Гол үзүүлэлтүүд:

	2019.12.31	2020.12.31	2021.03.31
Хүний нөөц	40	40	29
Цэвэр ашиг	2,187	1,241	2,390
Санхүүжилт	10,880	15,039	18,095
Нийт хөрөнгө	23,094	29,655	75,765
Зээлийн багц	18,430	20,297	25,114
Олгосон зээлийн хэмжээ	42,874	42,114	18,019

2020 онд 2019 онтой адилхан ажлын байраа хадгалж, хамгаалж, нэмэгдүүлэх боломж юу байна гэж ажиллалаа. 3/31-ний байдлаар 29 гэж байгаа нь 2020 онд бол энэ 40 ажилтаны 20 нь харилцагчийн үйлчилгээний төвд ажилдаг байсан, өсөн нэмэгдэж байгаа харилцагчдийн тоотой холбоотойгоор

ХҮТ-ийг Ард Кредит ХК-иас тусдаа гаргаад өдгөө 100 гаруй ажилтантай болсон байгаа тэгэхээр бодит компанийн өсөлт бол 29 буюу 20-оос 9 хүн нэмэгдсэн байгаа шүү.

Цэвэр ашгийн хэмжээний тухайд нэг юм тодотгох хэрэгтэй байх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, ОУ-ын аудитын компанийн зөвлөмжийн дагуу энэ жилээс тодорхой хэмжээний хэрхэн тайлагнах нь зүйтэй гэдэг дээр холбогдолтойгоор 2020 оны нийт цэвэр ашгийн хэмжээ 2 тэрбум боловч тайлан дээр 1,2 тэрбум гэж байгаа 3/31-ний байдлаар урьдмнө харагдаагүй, бидний үйл ажиллагааны үр дүн маань харагдаж 2,3 тэрбум төгрөгний цэвэр ашигт хүрлээ.

Санхүүжилт болон нийт хөрөнгийн хувьд бол 2020 өссөн үзүүлэлттэй, санхүүжилтийн хувьд бид 45 хувь өсгөж 15 тэрбумд хүргэсэн бол I улирлын байдлаар 18 тэрбумд хүрсэн байж байна.

Нийт хөрөнгө маань мөн 28 хувиар өсч 2020 онд 29.6 тэрбум төгрөгт хүрсэн байж байгаа, 2021 оны I-р улирлын байдлаар бараг 3 дахин 155 хувь өссөн 75,7 тэрбум байна.

2020 онд бол та бүхэн мэдэж байгаа МУ-ын эдийн засаг макро орчин цар тахлын нөлөөгөөр нилээн агшсан байдалтай байсан 5-аас дээш хувиар ДНБ агшсан мөн Банк, санхүүгийн байгууллагуудаас зээлийн хатуу бодлого баримтлаж, банкны салбарын зээлийн багц буурсан, банк санхүүгийн зээлийн багц бага зэрэг өссөн үзүүлэлттэй байсан. Бидний хувьд харилцагчиддаа зээлээ олгосоор байсан ингээд салбарын дунджаас өндөр буюу зээлийн багцаа 10 хувиар өсгөж 2020 онд 20,2 тэрбум төгрөг, I-р улирлын байдлаар 25,1 тэрбум төгрөг хүргэсэн байдалтай байна.

Олгосон зээлийн хэмжээ 2020 онд 2019 оны зээлийн хэмжээтэй адил хэмжээгээр олголоо, I улирлын байдлаар бол 18 тэрбум хүрсэн байна. Гол үзүүлэлтүүдийг товчхон байдлаар 2019, 2020 оны мөн 2021 оны I улирлын байдлаар танилцуулахад ийм байна.

Онцлох үйл явдал 2020 он

1. Түрүүн дурьдсанчлан 2020 он бол хэн ч тооцоолоогүй байсан цар тахлын нөлөөгөөр нийгэм сорилттой жил боллоо, тэр чигээрээ цар тахлын байдалтай 8 сар жил болж өнгөрсөн. Өнгөрсөн жилийн хувьд нийт бараг 8 сар нь олон нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллалаа. Он гараад ч гэсэн бид бараг 1 сар хагас бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт ажиллаж байна. Энэ хугацаанд бид харилцагчидтайгаа ойр байх ажлуудыг гүйцэтгэсэн байгаа. Харилцагчдыг энэ хөл хориотой байгаа үед гэрээг баталгаажуулах Монгол шуудантай хамтарч батлуулах ажлыг хийж, харилцагчидтайгаа долоо хоног бүр цагийг гаргаж, харилцагчиддаа халамжлах бодлогыг нэн тэргүүнд баримталж явлаа. Мөн төлбөрийн чадвар муудаж байгаатай холбоотой жижиг, дунд бизнесийн зээлийн шимтгэлийг 2020 онд 0 хувь болгож тэглэж өгсөн байгаа. Нөгөө талдаа цар тахал мэдээж буурах нь дамжиггүй энэ жил вакцинжуулалт хэр үр дүнтэй байхаас шалтгаалан хурдан сэргэх болов уу гэсэн найдлага байж байна. Үүнийг ч гэсэн Хятадын I улирлын байдлаар хөл хорио тавигдаад цар тахлаа тогтоон барингуут эдийн засаг нь 15хувиар шууд өсөж байгаагаас харж болно. Буцаад сэргэх болов уу гэж бодож байгаа тэр ч утгаараа бид урт хугацааны төслүүдээ ямар ч байсан явуулна гэсэн шийдвэртэй ажилласан. Энэ хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн байгаа, эхнийх нь буюу хамгийн том ажил нь:

1. Монголбанкны зохицуулалтанд орж Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг бол 2020 оны 5 сарын 20-нд авлаа. Энэ маань бид банкны төлбөр тооцооны үйлчилгээнд хэсэгчилсэн байдлаар оролцох боломжтой болсон гэсэн үг. Мөн оны сүүлээр дэд бүтэцдээ тодорхой хөрөнгө оруулалт оруулж Автомат Клиринг Хаус буюу банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шууд сүлжээнд холбогдлоо ингэснээр харилцагч бусад банкны интернэт банкин дээр банк хоорондын гүйлгээ хийхэд өөрийн Ард кредитийн данс руу шууд бодит орчинд гүйлгээ хийх боломжийг олгосон. Ингэснээр саатал болон тодорхой зүйлсүүд алга болж байгаа гэсэн үг юм. Мөн 2020 онд бид харилцагчдынхаа өмнө, ХЭ-ийнхээ өмнө амласан амлалтаа биелүүлэх ёстой тэр

үүргийнхээ хүрээнд Япон улсын Crowd Credit сангаас авсан санхүүжилтийн эргэн төлөлтийг өөрийн эх үүсвэрээр амжилттай эргэн төлөлтийг хийж чадсан нөгөө талдаа 2019 оны үр дүнд тулгуурлаж нийт хувьцаа эзэмшигчиддээ 1 тэрбум 92 сая төгрөгийн ногдол ашгийг тараасан байж байгаа.

2020 оны явуулсан урт хугацаанд үр дүнгээ үзүүлэх төслүүдээ явуулах нь зүйтэй байсан юмаа гэдгийг 2021 оны I улирал бататгаж харууллаа. Энэ нь 2 тоон үзүүлэлтээр харагдана.

1. Харилцагчдын тоо

Харилцагчдын тоо 2020 оны эцсээр 300,000 байсан бол 2021 оны I улирлын байдлаар 1 сая харилцагчид хүрлээ. Ард Кредит ХК-ийн харилцагчид боллоо, тэдгээр харилцагчид маань 2020 онд нэвтрүүлсэн Ард Кэш цахим мөнгийг ашиглаж байна, мөн автомат клиринг хаус буюу АСН-ийг ашиглаж байна, Ард апп-ын бусад үйлчилгээнүүдийг бидний авсан зөвшөөрлийн хүрээнд арилжаанд оролцох, хувьцаа авах, зээл авах, хадгаламж үүсгэх гээд ийм боломжуудыг эдлээд явж байгаа нөгөө талдаа 2020 оны эцсээр 2,100 хувьцаа эзэмшигчидтэй байсан бол хувьцаа эзэмшигчдийн тоо ганцхан улирлын дотор 4.7 бараг 5 дахин нэмэгдэж бидэнд итгэх итгэл нилээн өндөр байлаа. Бид үүнийг том харицлага гэдгийг ойлгож байгаа хувьцаа эзэмшигчдийн тоо 10,071 гаруй болсон байна одоогийн байдлаар. Түрүүн би эхэнд хэлсэн өчигдөрийн байдлаар 4,700 хүн бол бүртгүүлсэн байна. Яг 10 минутын өмнө 2,000 илүү хувьцаа эзэмшигчид маань энэ хуралдаа оролцож байгаа гэсэн мэдээлэл ирсэн байна. Өсөн нэмэгдэж байгаа харилцагч нартаа бид шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлж байна.

I улиралдаа багтаад бид Fast cash white буюу хөнгөлттэй зээлийн бүтээгдэхүүн гаргалаа, энэ нь манай хувьцаа эзэмшигч нарт зориулсан эхний 45 хоног хүүгүй дараагийн саруудаас нэн тааламжтай хүүгийн нөхцөлтэйгээр гаргалаа. Ингэснээр манай хувьцаа эзэмшигч 10,000 хүн нийт 1 сая харилцагч гэхээр нийт харилцагчийн 1 хувь нь хувьцаа эзэмшигч байна. Манай хувьцаа эзэмшигч нар маань энэ бүтээгдэхүүнүүдийг ашиглаж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

Тодорхой I дүгээр улиралд бид Монголбанк, СЗХ-той бид нилээн ойр ажиллалаа. Өсөн нэмэгдэж байгаа харилцагч, харилцагчийн шаардлага бол одоогийн мөрдөгдөж буй дүрэм журам нийцэхгүй байна гэдгийг бид удаа дараа гаргаж, яриа хэлэлцээр хийж хүргэж байгаа. Хамгийн сүүлд бол бид Монголбанкнаас үүнийг судалж үзье гэсэн тэгэхээр эерэгээр хариу гарна гэсэн хүлээлтэй байж байна. Цаашлаад бид салбарын хэмжээнд оролцоогоо нэмэгдүүлээд явж байна. Монголын банкны холбоонд албан ёсны гишүүнээр бид I дүгээр улиралд багтаж нэгдлээ. Монголын Финтекийн холбооны Удирдах зөвлөлд миний бие идэвхитэй ажиллаж байна. Өсөн нэмэгдэж байгаа харилцагчдаа 2021 оны I улиралд 16.5 сая ширхэг АрдКойныг урамшуулалд олголоо. Энэ нь одоогийн ханшаар 3.2 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон гэсэн үг юм. Түрүүн бас ямар урамшуулал харилцагчдаа олгож байгаа вэ гэсэн асуулт явж байх шиг байна. Нийтдээ 614 мянган харилцагчид урамшуулал олгосон байна. Та бүхэнд хувьцаа эзэмшигчдийн бүтцийг 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар болон 2021 оны 3 сарын 31-ний өдрөөр харьцуулан харуулья. 2021 оны I улиралд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж Ард Санхүүгийн Нэгдлийн хувь эзэмшлийн хэмжээ 60 гаруй хувиас 40 гаруй хувь болж буурсан байна. Энэ тодруулсан байгаа С.Оргил, Г.Бат-Эрдэнэ, Н.Мөнхнасан нар стратегийн хөрөнгө оруулагчаар орж ирсэн байна. С.Оргил бол Мост Финтек ХХК-ийн гүйцэтгэх захирал, Г.Бат-Эрдэнэ Монгол HD телевизийн Гүйцэтгэх захирал, Н.Мөнхнасан Мон Полимент компанийн ТУЗ-ийн дарга хувьцаа эзэмшигчээр орж ирсэн. Түрүүн тодотгож хэлсэнчлэн нийт 10,071 хувьцаа эзэмшигч бидэнд итгэж орж ирсэнд туйлын баяртай байгаа. Та бүхний итгэлийг алдахгүй хүлээлтэд хүрч ажиллахаа Гүйцэтгэх удирдлагын хувьд мэдэгдэж байна. 2020 он, 2021 оны I улирлын хувьцааны арилжааны мэдээг харуулья. 2020 онд бол түрүүн хэлсэнчлэн эдийн засгийн идэвхижлийн бууралттай холбоотойгоор нийт арилжааны дүн бага байлаа. Нийт арилжааны тоо 29.8 сая ширхэг, 2.2 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй арилжаа хийгдэж, доод ханш 60 төгрөг, дээд ханш 82 төгрөг байлаа. Нийт 29.8 сая ширхэг

хувьцаа арилжагдсан гэдэг нь манай нийт хувьцааны 10 хувь гэсэн үг юм. Энэ оны эхний улирлын байдлаар нийт арилжааны дүн 9.5 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт арилжагдсан хувьцааны тоо 70.9 сая ширхэг буюу нийт зарласан хувьцааны $\frac{1}{4}$ арилжаалагдсан байна. I улиралд хувьцааны ханш 275.6 төгрөгт хүрч түүхэн дээд ханшдаа хүрлээ. 4 сар гараад түүхэн дээд ханш эвдэгдээд явж байна. Компанийн бүтэц зохион байгуулалтыг та бүхэнд танилцуулья. Эрх барих дээд байгууллага хувьцаа эзэмшигчдийн хурал маань өнөөдөр хуралдаж байна. ТУЗ-ийн маань өөрийн дэргэд 3 хороотой Санхүү, зээл, эрсдэлийн хороо, Засаглалын хороо, Дотоод аудитын хороо ажиллаж байна. Энэ ялдамд ТУЗ-ийн нийт гишүүддээ талархал илэрхийлье. Өнгөрсөн жил Ковидтой амаргүй нөхцөл байдал ажилласан байгаа. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал миний бие доороо 3-н үндсэн чиглэлт Санхүү эрхэлсэн захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал, Зээл эрхэлсэн захирлуудтай ажиллаж байна. Манай Ард Санхүүгийн Нэгдлийн охин компаниудын хувьд бусад компаниас нилээн том онцлогтой байгаа. Ард Санхүүгийн Нэгдлээс эрсдэлийн удирдлага, санхүүгийн удирдлага, хууль хянан нийцүүлэх асуудлаар манайд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Санхүүгийн тайланг танилцуулья. Санхүүгийн тайланг танилцуулахаас өмнө банк бус санхүүгийн байгууллагын салбарын үзүүлэлтийг 2020 оны IV улирлын байдлаар танилцуулья. Банк санхүүгийн салбар нилээд зээлийн хатуу бодлого баримталсан. Тэр утгаараа банк бус санхүүгийн байгууллагын тоо 2019 онтой харьцуулахад 2020 онд нилээд буурсан үзүүлэлттэй байна. Гэтэл нөгөө талдаа нийт хөрөнгийн үзүүлэлт 2 их наяд төгрөгт хүрсэн байна. Нийт зээлийн багц 1.3 их наяд төгрөгт хүрч 7.6 хувиар өссөн. Гэхдээ өмнөх жилүүдтэй харьцуулахад төдийлөн өндөр өсөлт үзүүлээгүй. Шалтгаан нь түрүүн хэлсэн байгаа. Манай компанийн хувьд салбарын дундажаас өндөр буюу 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Орлого, цэвэр ашгийн хувьд өндөр өссөн байна. Зээлийн дундаж хүү 0.2 функтээр буурч 2.8 хувьд хүрсэн байна. Эндээс та бүхэн нэг зүйлийг анзаараасай гэж хүсч байна. Ер нь банк бус санхүүгийн байгууллагын хувьд дийлэнхи хөрөнгө нь өөрийн хөрөнгө байдаг. Ард Кредитын хувьд 2021 оны I улирлын байдлаар нийт хөрөнгөд эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ өндөр байгаа нь санхүүгийн зохистой хөшүүргүүдийг ажиллаж байна. Энгийнээр тайлбарлавал салбарын хувьд та бүхний оруулсан 1 төгрөгийг 7 төгрөг болгож байгаа бол манай компани таны оруулсан 1 төгрөгийг 10 төгрөг болгож байгаа гэсэн үг юм. Мэдээж дийлэнхи банк бус санхүүгийн байгууллагын гол үйл ажиллагаа зээлийн үйл ажиллагаа байдаг. Та бүхэнтэй зээлийн багцын чанарын үзүүлэлтийг хуваалцья. Зүүн талын графикт банк бус санхүүгийн байгууллагуудын 2019, 2020 оны зээлийн багцын чанар харагдаж байна. 2020 онд яах аргагүй салбарын хэмжээнд чанаргүй зээлийн хэмжээ нилээд муудаж ирсэн байна. Чанаргүй зээлийн багц 10.3%, хугацаа хэтэрсэн зээлийн багц 4.9% нийт 15.2 хувийн эрсдэлтэй зээлийн багц болж өссөн үзүүлэлт харагдаж байна. Ард Кредитын хувьд 2020 оны IV улирлын эцсээр эрсдэлтэй зээлийн багц 12.7 хувьд хүрч, үүний 9.4% нь чанаргүй зээлийн багц буюу салбарын үзүүлэлтээс 0.9 функтээр бага байдалтай байна. Бид I улиралд нэг талдаа чанаргүй зээлийг амжилттай бууруулж, нөгөө талдаа зээлийн багцаа чанартайгаар нэмэгдүүлсний үр дүнд чанаргүй зээлийн багцаа 7.8 хувиар бууруулж чадлаа. Ингэснээр манай эрсдэлтэй зээлийн багц 10.6% болон буурч салбарын дундажаас сайн үзүүлэлттэй гарсан байна. Зээлдэгчдийн тоо 2019 онтой харьцуулахад 2020 онд өссөн. 2021 оны I улирлын байдлаар 40,324-т хүрсэн байна. Харилцагчдын тоог бол өмнө дурьдсан байгаа. Зээлийн багц маань 2020 онтой харьцуулахад 24 хувиар өсч 25.1 тэрбум төгрөгт хүрчээ. Зээл олголт болон зээлийн эргэн төлөлт доод талын 2 графикт харагдаж байна. Энэ графикт 2019 он, 2020 он, 2021 оны өссөн дүнгээр харагдаж байгаа. Зээл олголт 2019, 2020 ондоо ойролцоо байсан байна. Зээлийн эргэн төлөлтийн хувьд 2020 онд илүү байжээ. Харин 2021 оны I улирал гараад улиралд дангаараа нийт олголт маань 18 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ хэвээрээ байвал оны эцсээр 2020 оныхоо үзүүлэлтийг хангалттай авч үлдэхээр байна. Нийт хөрөнгийн хэмжээг өмнө танилцуулсан. Нийт хөрөнгө 75.7 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнд тодорхой 3-н хүчин зүйл нөлөөлсөн. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө нэмэгдсэн ТУЗ-өөс өгсөн чиглэлээр нөхцөл байдал хэцүү байхад мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа нэмэгдүүлж явах нь зүйтэй гэсэн. Энэ чиглэлийн дагуу бид 2020 оны эцсээр 3.2 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө тайлагнаж байсан бол I улиралд 20.7 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь түрүүн дурьдсанчлан 2021 оны I улиралд төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлж эхэлсэнтэй холбоотой. Богино хугацаат хөрөнгө оруулалтын хувьд банк бус санхүүгийн

байгууллага гэхээр хүмүүс дийлэнхидээ зөвхөн зээл олгодог гэж ойлгодог. Манай банк бус санхүүгийн байгууллагын хувьд олон үйлчилгээ эрхэлдэг. Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх, богино хугацаат хөрөнгө оруулалт хийх, Монголбанкнаас олгосон төлбөрийн үйлчилгээ үзүүлэх ч гэдэг юм уу. Тэр хүрээнд бид нар богино хугацаат хөрөнгө оруулалтуудыг хийдэг. Үүний бодит үнэ цэнийн өсөлт 21.2 тэрбум төгрөгт хүрсэн. Оны эхэнд санхүүжилтүүд нилээн өссөн байна. Эдгээр факторууд нөлөөлж манай нийт хөрөнгө маань 2021 оны I улиралд 75.7 тэрбум төгрөгт хүрснийг та бүхэн харж болно. Энд нэг онцлох зүйл маань өөрийн хөрөнгө маань нэмэгдсэн. Банк бус санхүүгийн байгууллага бол Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг учир эх үүсвэр татах дээр нилээд хязгаарлалтууд байдаг. Үүнд бол ашигт ажиллагааг хангаж, өөрийн хөрөнгийн бодит үнэ цэнийг өсгөж чадсанаар бид нар өөрийн хөрөнгийг 2021 оны I улирлын байдлаар 29.9 тэрбум төгрөгт хүргэснээр энэ оны үлдэх хугацаанд санхүүжилт татах боломж маань нэмэгдсэн. Үйл ажиллагааны орлого 2019 оныг 2020 онтой харьцуулахад өссөн байна. 2021 оны I улиралд дангаараа 4.1 тэрбум төгрөгт хүрснийг та бүхэн харж байна. Ингээд үр дүнгээр 2020 оны цэвэр ашиг маань 1.2 тэрбум төгрөг, 2021 оны I улиралд 2.3 тэрбум төгрөг гарсан байна. Өмнө хэлсэн нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, олон улсын аудитын байгууллагын зөвлөмжөөр нийт дэлгэрэнгүй орлого маань 2020 маань 2.071 тэрбум төгрөг, I улирлын байдлаар 19.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн үзүүлэлттэй ажиллаж байна. Санхүү байдлын тайланг маш товчхон ярь. Гол үзүүлэлтүүдийг өмнө дурьдсан учир. Та бүхэн эндээс нийт хөрөнгийн хэмжээгээ харах хэрэгтэй. Оны өмнөөс бол 155 хувиар өссөн. 2020 оныг 2020 онтой харьцуулахад 28 хувь өссөн. Гол нөлөөллүүдийг өмнө хэлсэн. Өсөлтийн хувиудыг та бүхэн хараад аваарай. Эргэлтийн хөрөнгө маань 55.7 тэрбум төгрөгт хүрсэн. Үүнд бол анхаарлаа хандуулаарай. Биет болон биет бус хөрөнгө. Үүнд нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, өөрчлөлтэй холбогдолтой аудитын байгууллагын зөвлөмжөөр оруулсан. Нийт өр төлбөр ба өр төлбөр 75.7 тэрбум төгрөг. Нийт өр төлбөрт өөрийн хөрөнгийн хэмжээ 29.9 хувь байна. Орлого, үр дүнгийн тайлан задаргаатайгаа хамт харагдаж байна. 2020 онд 2019 онтой харьцуулахад хүү болон түүнтэй адилтгах орлого 64.7% өсөж, 6.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2021 оны I улиралд дангаараа 1.7 тэрбум төгрөгтэй. Цэвэр хүүнээс 1.4 тэрбум төгрөгийн ашиг хуримтлагдсан. 2021 оны I улиралд цэвэр ашиг маань 2.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Банк бус санхүүгийн байгууллага Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны зохицуулалтад байдгийн хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах шаардлагатай байдаг. Нийт хөрөнгийн өгөөж 11.3 хувиас нэг улирлын дотор 16.6 хувь боллоо. Нийт хөрөнгийн өгөөж 4.6 хувиас 6.6 хувь болж өссөн байна. Хөрвөх чадварын харьцаа төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг харуулж байдаг. Үүнийг СЗХ-ны зохистой харьцаа доод тал нь 8 хувь байх ёстойг 2020 онд 7.8 хувь байсан бол 2021 оны I улиралд 9.4 хувьтай хангаж байна. Эх үүсвэр татан төвлөрүүлэх орон зай хэр үүссэн юм бэ гэдгийг та бүхэнд харуулж байна. Итгэлцэл өөрийн хөрөнгөд эзлэх хэмжээ 80 хувь байдаг бол дүнгэж 34.6 хувьтай байна. Бонд өөрийн хөрөнгөд эзлэх хувь 10.5 хувьтай байна. Бид санхүүгийн хөшүүргийг үзүүлэх боломжтой. Мөн эрсдэлтэй зээлийг хааж байдаг нэг чухал үзүүлэлт болох нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээ 30 хувь байдаг бол 10.7 хувьтай байна. Банк бус санхүүгийн байгууллагын ТУЗ болон Гүйцэтгэх захиралд олгох зээлийн хэмжээ 10 хувиас хэтэрч болдоггүй бол 3.7 хувьтай. 2020 он болон 2021 оны I улиралд мөн адил зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласныг мэдэгдэхэд таатай байна. Баярлалаа та бүхэндээ. Нэгэнт 2021 оны I улирал гарсан тул 2021 оны I улирлын үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцууллаа.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Манай Гүйцэтгэх захирлын зүгээс санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа. Үүнтэй холбоотой Грант Торнтон аудит компаниас манай аудиторуд өнөөдрийн хуралд оролцож байгаа. Аудиторын компанийн Эрдэнэцог партнер, аудитор Батцоож нар танилцуулгаа хийнэ. Грант Торнтон дэлхийд хамгийн том 5-т ордог, олон улсын аудитын компани байгаа. Энэ жил анх удаа хамтарч ажиллан Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын аудитыг хийлгээд байна. Бид бүхэн үйл ажиллагаагаа аман дээрээ нээлттэй ил тод явуулах биш мэргэжлийн байгууллагуудаар дүгнэлт гаргуулан та бүхэнд хүргэх үүрэгтэй байдаг.

Грант Торнтон аудит ХХК-ийн партнер Эрдэнэцог: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Грант Торнтон аудит маань Ард Санхүүгийн Нэгдэл болон группын хэмжээнд энэ жил аудит хийж байна. Ард Кредит бол томоохон охин компанийн нэг юм. Грант Торнтон аудит бол дэлхийн 130 гаруй оронд өөрийн салбар оффистой, 58 мянган аудитор мэргэжлийн зөвлөхүүдээс бүрдсэн дэлхийн тэргүүлэх 6-н фирмийн нэг юм. Грант Торнтоныг 2019 оны 1 сараас Монгол улсад албан ёсоор зарлаж үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Өмнө нь бид Улаанбаатар аудит корпораци гэх Монголын аудитын зах зээлд 20 гаруй жил үйл ажиллагаагаа явуулсан компани байгаа юм. Өнөөдрийн байдлаар 5 партнер, 40 гаруй ажилтантай. 14 мэргэшсэн нягтлан бодогчидтой ажиллаж байна. Ард Кредит Хувьцаат компанийн санхүүгийн тайланд аудит хийсэн гол асуудлыг товчхон танилцуулъя. Үндсэндээ бол компанийн Гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангаа олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулах үүрэгтэй байдаг. Мөн эдгээр санхүүгийн тайланг бэлтгэхдээ аливаа алдаа дутагдалгүй, зөрчилгүй, материаллаг буруу илэрхийлэлгүй байх, санхүүгийн залилан мэхлэх шинжгүй байх үүргийг хүлээж байдаг. Компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс тайланг бэлтгэхэд засаглах эрхтэй этгээдүүд гэж санхүүгийн тайлангийн олон улсын стандартаар ярьдаг буюу Төлөөлөн удирдах зөвлөлийг хэлдэг. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартад хяналт тавих үүрэгтэй байдаг. Аудиторын хувьд бид ямар үүрэгтэй вэ гэхээр компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан бүхэлдээ ямар нэгэн алдаа, зөрчилөөс үүссэн аливаа буруу илэрхийлэлгүй байх дээр ул үндэслэлтэй нотолгоо олж, үүн дээрээ дүгнэлт гаргадаг байгаа. Мөн түүнчлэн компанийн дотоод хяналт хэр үр дүнтэй байна гэдэг дээр тухайн нөхцөл байдлыг дүгнэсэн аудитын горим боловсруулж, дотоод хяналтын орчны талаар тодорхой ойлголттой болдог. Компанийн бэлтгэсэн санхүүгийн тайланд ашигласан арга нь олон улсын стандартад хэр нийцсэн юм, нягтлан бодох бүртгэлийн гаргасан тасралтгүй байдал нь хэр зэрэг зохистой байсан, цаашид тэр компани тасралтгүйгээр үйл ажиллагаагаа явуулах чадамж хэр зэрэг байгаа вэ гэдэг дээр тодорхой үнэлэлт, дүгнэлт өгдөг. Эцэст нь санхүүгийн тайлан болон түүний тодруулгыг бүхэлд нь ерөнхий толилуулгыг хийж, бүтэц, агуулга нь хэр байна гэдгийг үнэлж, гол ажил гүйлгээг санхүүгийн тайландаа тусгасан эсэхийг үздэг. Сая бол санхүүгийн гол үзүүлэлтийг Тэлмэн захирал дэлгэрэнгүй танилцуулсан учир давтаж ярихгүй байх нь зөв байх. Гэхдээ энд нэг ярих зүйл байгаа нь компанийн санхүүгийн тайланд ялангуяа криптовалюттай холбоотой нягтлан бодох бүртгэлийн томоохон өөрчлөлт, залруулгыг хийсэн байгаа. Криптовалютын бүртгэл бол Монгол улсад шинээр орж ирж байгаа. Үүнийг хэрхэн яаж бүртгэх вэ гэдэг олон улсын тухайлсан стандарт бол гарч амжаагүй. Одоо бол санхүүгийн тайлангийн стандартын хүрээнд гарсан олон улсын зөвлөмжийн хүрээнд ерөнхийдөө бол биет бус хөрөнгөөр бүртгэх нь зүйтэй юм байна. Энэ нь Ард Кредитэд илүү тохиромжтой юм байна гэсэн сонголтыг компанийн удирдлагатай зөвшилцсний үндсэн дээр зохих залруулгуудыг хийсэн байгаа. Тэгээд нийт дүнгээрээ компанийн нийт дэлгэрэнгүй орлогыг 2.1 тэрбум төгрөгөөр илэрхийлсэн. 1.2 тэрбум төгрөгөөр тайлант хугацааны цэвэр ашгийг бүртгэсэн. АрдКойны ханшийн өөрчлөлттэй холбоотой 0.8 тэрбум төгрөгийг өмчийн өөрчлөлтийн тайлан хэсэгт дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч нийт дэлгэрэнгүй орлого 2 тэрбум төгрөг болсон. Ард Кредит маань үндсэндээ финтек компани. Гар утасны аппликэйшнд суурилж, хэрэглэгчдэд зээл олгоод явж байгаа. Өөрөөр хэлбэл хүний оролцоо бага, технологит суурилсан зээлийг автоматаар олгодог процесс байгаа. Зээл олголтын процесс үнэн зөв явж байгаа эсэх дээр зайлшгүй мэдээллийн технологийн аудит хийх шаардлага гарч ирж байна. Бид зүгээр нэг банк бус санхүүгийн байгууллага дээр аудит хийх бол зээлийн хувийн хэргүүдийг бүгдийг авч үзээд шалгадаг бол одоо бол бүх зээлдэгчдийн мэдээлэл сервер дээр хадгалагдаад эргүүлээд автоматаар зээлүүд авч байгаа тул зайлшгүй мэдээллийн технологийн аудит хийх шаардлагатай болсон. Манай аудитын баг мэдээллийн технологийн аудит орж ажилласан. Үүнд мэдээллийн технологийн аудит хэр зэрэг байгаа юм, тусгай аудит хэр зэрэг байгаа юм, санхүүгийн программ хангамжийн хяналт ямар байна, түүнээс гадна Монголбанкнаас баталсан Сэндбоксын шаардлагад хэр нийцэж байгаа юм бэ гэсэн ийм асуудлуудыг тодорхой аудит хийсэн. Аудитын үр дүнд гарсан алдаа, зөрчил дутагдал санхүүгийн тайланд нөлөөлөхгүй боловч компанийн анхаарах шаардлагыг менежментийн захидлаар компанийн удирдлагад танилцуулсан байгаа. Ерөнхийдөө бол аудитын дүгнэлтээр компани зөрчилгүй дүгнэлт авсан байгаа. Тодорхой зарим нэг залруулгуудыг

хүлээн зөвшөөрч дүгнэлт өгсөн. Дээр нь нэмж хэлэх гол асуудал бол санхүүгийн тайлагналын гол стандарт СТОУС-9 стандартыг компани зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Яагаад гэхээр СТОУС-9 гэдэг стандартыг дэлхий даяар 2018 онд дагаж мөрдөж эхэлсэн. Ард Кредит компани нь олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн хувьцаат компани гэдэг утгаараа нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу СТОУС-9-ыг зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай юм. Зээл олгодог компанийн хувьд зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох аргачлал маань компани зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай юм байна гэж үзсэн. Компанийн санхүүгийн тайлан гаргахдаа ашигласан Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан активыг дахин ангилах тухай журам байж байгаа. Энэ журмын дагуу зээлийн эрсдэлийн сангаа байгуулсан. Гэхдээ олон улсын стандартын дагуу арай өөр журмаар байгуулах шаардлагатай. Тухайлбал, зээлийн үнэ цэнийн бууралтыг СТОУС 9 –ын дагуу хэрэгжүүлж үүнийхээ дагуу зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцож байх нь зүйтэй гэсэн гол асуудлыг аудитын тайлангаар хөндөж тавьсан байгаа. Ерөнхийд нь базаад хэлэх юм бол компанийн ялангуяа тасралтгүй үйл ажиллагаа талаас харвал, аудит хамгийн багадаа 1 жил түүнээс цааш тасралтгүй үйл ажиллагаа явуулах ёстой гэдэг утгаараа сая 2021 оны I улирлын тайлангаар маш өндөр өсөлттэй харагдаж байгаа бөгөөд компанийн хувьд өөдрөг харагдаж байна. Ингээд 2020 оны санхүүгийн тайланг аудитын зүгээс зөрчилгүй, олон улсын стандартын дагуу материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн. Товч танилцуулахад ийм байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Батцоож аудитор, Грант Торнтоны үүсгэн байгуулагч, түнш Эрдэнэцог нартаа баярлалаа.

Бид та бүхэнтэйгээ Монголд ажиллаж эхэлсэн эхний жилдээ хамтарч ажиллаж байгаадаа баяртай байна. Цааш цаашдаа та бүхнээсээ зөвлөгөө, мэргэжлийн туслалцааг авч ажиллах болно. Монголдоо шинэлэг зүйл хийж байгаагийн хувьд та бүхэнтэйгээ хамтарч ажиллах болно. Ингээд Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс 2020 оны гүйцэтгэлд тулгуурлаад ногдол ашиг олгохоор болсон. Үүний өмнө бид 2019 онд ногдол ашиг тараах шийдвэр гаргаж байсан. Энэ талаар Гүйцэтгэх захирал Тэлмэн та бүхэнд мэдээлэл хүргэнэ.

2. Ногдол ашгийн тайлан;

Тэлмэн: 2020 оны 3 сарын 26-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын дагуу 2019 оны компанийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг үндэслэн нийт 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашгийн 50 хувийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр тараах шийдвэрийг гаргасан. Үүнд бол нэгж хувьцаанд 3.9 төгрөг ногдож байсан. Бүртгэлийн өдрийг 2020 оны 4 сарын 8-ны өдрөөр тооцож байсан. Онцолж хэлэх зүйл бол түрүүн бас хэлж байсан, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас Ард Кредит хамгийн эхэнд ногдол ашгаа тарааж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв рүү 4 сарын 29-ний өдөр шилжүүлж, нийт 1,632 хувьцаа эзэмшигчдээ 2019 оны үр дүнгээс 2020 онд ногдол ашгийг тараасан байна.

3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан;

Хурлын дарга Ч.Ганхуяг: Манай Төлөөлөн удирдах зөвлөл үндсэн чиг үүргийнхээ дагуу 2020 онд ажлаа зохион байгуулж ажилласан. Миний хувьд энэ компанийн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж, нилээд оролцоотой ажиллаж ирсэн. Мэдээж Гүйцэтгэх удирдлага солигдсон талаар та бүхэнд хэллээ. 2019 онд хагас жилийн хугацаанд орон зай үүссэн. Өнөөдөр ковидтой үед цахимаар хуралдах шаардлага гарч байсныг дурьдах нь зүйтэй. ТУЗ бол үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүргээ нэр төртэйгээр биелүүлж, гүйцэтгэх удирдлагыг тасралтгүй чиглүүлж ажиллаж чадлаа. Тэр нь манай компанийн үр дүнд харагдаж байна. Нийт удирдах зөвлөлийн гишүүдэд баярласан талархснаа илэрхийлье. Манай ТУЗ-ийн гишүүн С.Гэрэлтуяа ажлын ачааллаас шалтгаалан чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн байгаа. Түүний гэр бүлийн гишүүн болох О.Одбаяр ердийн гишүүнээр ажиллах хүсэлтээ өгсөн бөгөөд өнөөдөр нэр дэвшиж байна. Манай Интергрупп Интернэшнл дээр ажиллаж байсан В.Баяржаргал хувиараа хөрөнгө оруулалт хийж байгаад 12 сард хувьцаагаа худалдсны дараа чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн Баяржаргал маань 2013 оноос хойш хамтарч байгаад өөр бизнест хөрөнгө оруулалт хийж чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн. Ч.Ганзориг 2013 оноос Ард Кредитын Гүйцэтгэх захирлаар 2019 оныг дуустал тасралтгүй ажиллаж байгаад чөлөөлөгдөж, хувийн бизнесээ хийж байгаад одоо Ард Экс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Цаашид ч компанийн ердийн гишүүнээр ажиллах байгаа. М.Тулгат гишүүн маань улс төрийн том албан

тушаалд томилогдсон тул чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан. Цаашдын ажилд нь амжилт хүсье. И.Баттуяа гишүүн IPO хийхэд хувьцаа авч орж ирээд хувийн бизнесийн улмаас гарч, чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Надтай хамт Хасаас эхэлж хамт ажилласан, Ард Санхүүгийн Нэгдлийн үйл ажиллагаанд орж ирээд статус нь өөрчлөгдөж магадгүй байгаа. Олны дунд Вэнзогоор алдаршсан В.Ганзориг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байна. Мөн өнөөдөр нэр дэвшээд байгаа Чулуунзоригтын Чинзоригт Моннисын дэд захирал маань ажиллах хүсэлтээ гаргаад байна. Хэлэлцэх асуудлын өмнө нэр дэвшигчдийн танилцуулга хийгдэх тул та бүхэн маань танилцаад саналаа өгөөрэй. Мөн түүнчлэн шинээр 3 гишүүн нэр дэвшиж байна.

Манай ТУЗ олон улсын жишгийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ дэргэдээ Санхүү, зээл, эрсдэлийн хороотой, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороотой, Дотоод аудитын хороотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Ковидтой үед бид 7 хоног тутам компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, Хороод маань илүү олон давтамжтай хуралдах зайлшгүй шаардлага үүссэн. Ямартай ч энэ үеийг маш амжилттай залуурдсаар байгаад компаниа авч гарч ирж чадлаа. Энэ дундаас ногдол ашиг тараах талаар шийдвэр гаргасан. Бид ээлжит болон ээлжит бусаар 5 удаа хуралдаж, эчнээ 15 хурал хийж, 33 асуудлыг шийдвэрлэсэн байна. Түрүүн манай захирал танилцуулснаар 2020 оны үр дүнд үндэслээд ногдол ашиг тараах шийдвэрийг гаргасан. Манай компанийн хөрөнгийн дийлэнхи хэсэг нь бэлэн мөнгө байгаа. Амжилтаасаа хувьцаа эзэмшигчидтэйгээ хуваалцаад 4 сарын 9-ний өдрөөр тасалбар болгон 1,000,000,000 төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргасан. Мөн 50 нэгж хувьцаанд 1 АрдКойн тараах шийдвэр гаргасан. Ингээд манай 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд гаргасан дүгнэлтийг танилцуулна уу хэмээн В.Ганзориг гишүүнд микрофоноо шилжүүлье.

3.2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлт:

ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг: Би хараат бус гишүүний хувиар 2020 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулъя. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан 2020 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь шинэ төрлийн Коронавирус цар тахлын үед үйл ажиллагаагаа тасалдалгүй хэвийн явуулах, ашигт ажиллагааг хадгалах, ажиллагсдыг цомхотгохгүй ажлын байрыг хадгалах, ажлын байрыг нэмэгдүүлэх, шинэ, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх байлаа. Мөн хууль, журмын хэрэгжилтийг хангуулж эрх бүхий байгууллагуудаас холбогдох зөвшөөрлийг авах, харилцагч төвтэй үйлчилгээг сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зэрэг байсан болно. 2020 онд Ард Кредит ББСБ ХК-ийн нийт актив 29.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 28 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд оны эцсийн байдлаар зээлийн багц 20.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт 15.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлж, 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, 2.1 тэрбум төгрөгийн нийт ашигтай ажиллажээ. Үйл ажиллагааны хувьд дараах онцлох үзүүлэлтүүдийг үзүүлжээ. Үүнд:

1. Ард Аппын таталтын тоо 637.0 мянгад, Харилцагчийн тоо 356.8 мянгад, Зээлдэгчийн тоо 19.1 мянгад хүрсэн үзүүлэлтийг үзүүлжээ.
2. Монголын Хөрөнгийн Биржийн 2020 оны ТОП-20 индексийн сагсанд Ард Кредит ББСБ ХК багтсан бөгөөд 2021 оны I улирлын байдлаар хувьцааны ханш түүхэн дээд ханшдаа хүрээд байна. Анх олон нийтэд нэгж хувьцаагаа 70-85 төгрөгийн хооронд санал болгосон бөгөөд 2020 оны түүхэн дээд ханш нь 2020 оны 12 сарын 31-ний өдөр 82.1 төгрөг, 2021 оны I улирлын түүхэн дээд ханш нь 2021 оны 3 сарын 16-ны өдөр 275 төгрөгт хүрлээ.
3. Монголбанкнаас Ард Кредит ХК-д Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосноор банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхэлсэн. Ингэснээр уг зөвшөөрлийг авсан анхдагч банк бус санхүүгийн байгууллагуудын нэг боллоо.

4. EuroGiro Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 10 сарын 2-ны өдөр Монгол Шуудан ХК-тай хамтран зах зээлд нэвтрүүлэв. АНУ, БНСУ, Хятад, ОХУ, Австрали, Турк, Их Британи, Европын Холбооны улсууд гэх мэт дэлхийн 50 гаруй улсын 500 мянган төлөөлөгчөөр дамжуулан ЕвроЖайро мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах боломжтой бөгөөд шимтгэл хураамжийн хувьд бусад өрсөлдөгч байгууллагууд (Western Union, MoneyGram г.м)-тай уялдуулан тухай бүр шинэчлэн тогтоодог. 2020 оны 10 сараас 2021 оны 3 сар хүртэлх хугацаанд 91,327 евро буюу 314.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.
5. АСН+ (Автомат Клиринг Хаус) банк хоорондын шууд гүйлгээний системийг амжилттай нэвтрүүлээд байна. АСН системд холбогдсоноор төлбөр тооцооны үйлчилгээг хурдан, шуурхай бодит горимд алдаагүй хийх боломжтой. Бусад банкуу болон Бусад банкны Интернет банк болон Банк хоорондын гүйлгээнээс шууд Ард Кредит дээр өөрийн дасныг сонгож оруулах боломжтой. Ийм гүйлгээ хийдэг хоёр л ББСБ байдаг Мобифинанс болон Ард Кредит АСН системд холбогдоод байна.

Мөн түүнчлэн Монгол орны өнцөг булан бүрт байгаа харилцагчдадаа үйлчилгээгээ үзүүлэх зорилгоор Fast Cash хэрэглээний зээлийг хөдөө орон нутагт нэвтрүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэжээ. 2020 онд цар тахлын нөлөө болон эдийн засгийг эрсдэлтэй зэрэгцээд банк санхүүгийн зээлийн зах зээл хумигдсан бол Ард Кредит энэхүү үйлчилгээгээ тасралтгүй үргэлжлүүлэн харилцагчдад хүргэсээр байна. 2020 онд салбарын дунджаас өндөр зээлийн өсөлт үзүүлсэн. Түргэн шуурхай, барьцаагүй, тухайн хүний зээлийн төлөлтөөс хамаарч дараагийн удаа хүү буурч хэмжээ өсөж явдаг дүрэмтэй. Олон 10, олон 100 удаа энэ үйлчилгээг байнгын ашиглаж ажил амьдралаа зохицуулдаг олон мянган харилцагчтай болоод байна.

Иймд Ард Кредит ББСБ ХК-ийн гүйцэтгэх удирдлага 2020 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна. Ингээд та бүхэнд амжилт хүсье.

Ганхуяг: Баярлалаа, Ганзоригтоо. Манай ТУЗ тэр бүр гарт харагдаад байдаггүй нарийн ажлыг хийдэг. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хооронд та бүгдийн өмнөөс компанийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж үйл ажиллагааг тасралтгүй хангах байдаг. ТУЗ-ийн гишүүдийн хувьд нилээд ачаалалтай, мэргэжил, мэргэшил шаардсан ажил юм. Сүүлийн үед хувьцаа эзэмшигчид бол ТУЗ-ийн ач холбогдлыг маш сайн ойлгодог болоод байгаа. Ингээд бүгдээрээ хэлэлцэх асуудлын дагуу ТУЗ-ийн гишүүний нөхөн сонгуулийг явуулахаар болоод байна. Нөхөн сонгууль ямар учиртай талаар Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн тайлбарлана.

4. ТУЗ-ийн гишүүдийг нөхөн сонгох.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: 2019 онд манайх нээлттэй хувьцаат компани болсноор 3 жилийн хугацаатай сонгосон. Дараа жил ТУЗ-ийн гишүүдийн сонгууль явуулахаар байгаа. Түрүүн танилцуулсанчлан Ердийн 3 гишүүн, хараат бус 2 гишүүний чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөнтэй холбогдуулан нөхөн сонгууль явуулна. Сая хувьцаа эзэмшигч маань асуусан байна. Сонгон шалгаруулалт хэрхэн явагдсан талаар асуусан байна. Нөхөн сонгууль явуулах орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалт явуулсан бөгөөд Ард Кредитын 100,000 гаруй дагагчтай хуудсаар зараа тавьж, оролцсон хүмүүс маань нэр дэвшин орж ирсэн байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Нэр дэвшигчдээс орж ирсэн хүмүүс танилцуулгаа хийнэ гэсний дагуу ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчид танилцуулгаа хийв.

Кумулятив аргаар санал өгөх зааврыг тооллогын комисс танилцуулав.

5. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар танилцуулга хийгднэ.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Зохицуулагч байгууллагын шаардлага, мөн компани тусгай зөвшөөрөл нэмж авсантай холбогдуулан компани дүрэмдээ 3-н үндсэн чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байна. Үүнд: Монголбанкнаас Цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрөл авсантай холбогдуулан үйл ажиллагааны чиглэлийг үйл ажиллагааны чиглэлд нэмж байгаа. Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн чиглэлийн дагуу хаалттай өрийн бичиг гаргах чиглэлийг хасч байна. Хорооноос баталсан Хувьцаат компанийн хурлын зар хүргэх журмын дагуу Цахимаар хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах зохицуулалтыг дүрэмдээ нэмж оруулахаар санал оруулж байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Та бүхэн хэлэлцэх асуудлуудын танилцуулга хийгдэж дууссан тул саналаа өгөөрэй. Мөн олгох урамшууллын талаар Гүйцэтгэх захирал танилцуулна.

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн: Өнгөрсөн жилийн ногдол ашгийг 4 сарын 9-ний өдрөөр тараана. Хуралдаа оролцож байгаа хүмүүст хурлын өдөр буюу 4 сарын 30-ны өдөр хуралдаа оролцож байгаа, өнөөдрийн байдлаар хувьцаа эзэмшиж байгаа хүн бүрт 100 АрдКойныг олгохоор болж байна. Энэ жил манай компанийн 10 жилийн ой болж байгаа мөн хувьцаа эзэмшигчдийн тоо 10,000 гарсан учир урамшууллыг олгож байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Ингээд асуулт, хариултын хэсэгтээ орьё. Хүмүүс комментоор нилээдгүй асуулт ирүүлээ. Энэ хооронд манай хувьцаа эзэмшигчид саналаа өгч байгаарай. ТУЗ-ийн гишүүд сонгох, дүрмийн нэмэлт, өөрчлөлт оруулах, ТУЗ-ийн дүгнэлт батлах асуудал дээр саналаа өгөх юм.

Асуулт, хариулт.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Нэг ийм асуулт байна. Хувьцаа яагаад буурдаг вэ? Хувьцаа маш олон шалтгааны улмаас хувьцааны үнэ буурдаг. Хөрөнгийн зах зээл дээр хүмүүс хувьцаагаа зарахын тулд үнээ бууруулж захиалгаа өгөн нөгөө талдаа авах эрэлт хангалттай байхгүй бол хувьцааны үнэ буурдаг. Энэ бол эрэлт, нийлүүлэлтийн дагуу зах зээлийн хууль юм. Эсхүл нөгөө талаасаа компанийн талаар муу мэдээлэл гарах, ашигт ажиллагаа буурсан тохиолдолд хувьцааны үнэ ханшид муугаар нөлөөлдөг. Мөн орчны нөлөөлөл байдаг. Ковид гарлаа, энэ компани зээлээ төлүүлж чадахгүй нь гэсэн мэдээллээс болж хувьцааны үнэ ханшид нөлөө үзүүлэх тохиолдол байдаг. Хувьцааны ханшийг тооцож үзэхдээ хөндлөнгийн аудитын газраас гаргасан дүгнэлтийг авах, анхдагч эх сурвалжаас мэдээллийг авах шаардлагатай.

АрдКойн эзэмшигч энэ хуралд оролцож болох уу гэж асуусан байна. Энэ хуралд АрдКойн эзэмшигч оролцохгүй. АрдКойны талаар мэдээллийг орой 7 цагт мэдээлэл хийнэ.

ТУЗ-д нэр дэвшүүлэх талаар асуулт ирсэн байна. Бид тодорхой журмын дагуу сонгон шалгаруулалт хийж, Засаглалын хороогоор хэлэлцэж, уулзалт ярилцлага хийдэг байгаа.

Ард Кредит цаашдаа банк болох уу? Гэсэн асуулт байна. Бид банкттай төстэй байдлаар үйл ажиллагаагаа явуулж байгаа учир банк болохгүй. Банк бус санхүүгийн байгууллагаараа үйл ажиллагаагаа явуулна. Монголбанкнаас Цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрөл авсан байгаа. Бид цаашид тун удахгүй шинэ, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулах болно. Санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэх боломжтой Аппыг нэвтрүүлсэн байгаа.

Санал, хураалтыг хурлын дэгийн дагуу 15 минут явуулав.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Санал, хураалт явагдаж дууссан байна. Санал хураалтын дүнг танилцуулна уу хэмээн Алтансүхийг урьж байна.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх: Тооллогын комиссын тогтоолыг танилцуулья. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг танилцуулъя.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтын дүнг танилцуулах нь:

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтад 241,673,943 ширхэг хувьцаа буюу 87.54 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

- Зөвшөөрсөн 209,934,711 ширхэг буюу 86.87 %
- Татгалзсан 22,898 ширхэг 0.01 %
- Түдгэлзсэн 3,408 ширхэг 0.001 % байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулан батлах тухай санал хураалтын талаарх дүнг танилцуулах нь:

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулан батлах тухай санал хураалтад 241,673,943 ширхэг энгийн хувьцаа буюу 87.54 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

- Зөвшөөрсөн 198,188,068 ширхэг буюу 82.01 %
- Татгалзсан 68,173 ширхэг 0.03 %
- Түдгэлзсэн 13,688 ширхэг 0.01 % байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг нөхөн сонгох тухай санал хураалтын дүнг танилцуулах нь:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг нөхөн сонгох тухай санал хураалтад 241,673,943 ширхэг энгийн хувьцаа буюу 87.54 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
Ердийн гишүүд		
1	Одончимэдийн Одбаяр	195,544,286
2	Хишигдоржийн Батхишиг	193,360,725
3	Гэрэлтийн Тэлмэн	200,833,147
Хараат бус гишүүд		
1	Чулуунзоригтын Чинзоригт	189,351,135
2	Батсүрэнгийн Солонго	189,625,310
3	Бороохойн Энхболд	12,440,575

Хурлын даргалагч Ч.Ганхуяг: Тооллогын комисстоо баярлалаа. Өнөөдрийн Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал амжилттай явагдаж өндөрлөлөө. Тооллогын комиссын танилцуулсан тайланд үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг танилцуулъя. **Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр О.Одбаяр, Г.Тэлмэн,**

Х.Батхишиг, хараат бус гишүүнээр Б.Солонго, Ч.Чинзоригт нарыг томилох, Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулан батлах шийдвэрийг тус тус гаргалаа.

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдэд сайн сайхан бүхнийг хүсье. Шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдэд баяр хүргэе. Он удаан жил хамтран ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүдэд баярлалаа. Дохионы хэлмэрчдэд баярлалаа. Тооллогын комисстоо талархал илэрхийлье. Грант Торнтон аудит ХХК-ийн хамт олондоо баярлалаа. 2021 онд өмнөх жилүүдийнхээ бүх амжилтыг дагуулсан амжилтыг гаргаарай. Хүчтэй, Хамтдаа. Хурал хаасныг үүгээр мэдэгдье гэснээр 13.30 цагт хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА:
Ч.ГАНХУЯГ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
М.МӨНХСҮРЭН